# МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР, МЭДЛЭГ, ЗААХ АРГА ЗҮЙ, СЭТГЭЛ ХАНАМЖ МАНЛАЙЛАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Д.Гэрэлбаатар
Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн ахлах багш, доктор, цагдаагийн хурандаа

Э.Анхбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын
академийн 8012 дугаар дамжааны магистрант,
хошууч

***Товч агуулга:*** Сүүлийн жилүүдэд хил хамгаалах байгууллагын хөгжил, бие бүрэлдэхүүний манлайллыг дээшлүүлэх чиглэлд онцгой анхаарч зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Иймээс хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж хилийн ангид ажиллаж буй офицер бүрэлдэхүүний манлайлалд дүн шинжилгээ хийх үүднээс PERMA загвараар, судалгааг чанарын судалгааны арга зүйгээр авч, SMART-PLS-3.0 программыг ашиглан нэгтгэн дүгнэж, задлан шинжлэн, хүчин зүйлийн шинжилгээ, замын шинжилгээ хийж, үр дүнгүүдийг харьцуулах замаар дүгнэхийг зорьсон.

***Түлхүүр үгс:*** Манлайлал, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн мэдлэг, заах арга зүй, сэтгэл ханамж

## Оршил

Манлайлал хүмүүсийн үнэт зүйл, зан төлөв болон хандлагад нөлөөлж, өөрчлөлт, шинэчлэлийг удирдан нэг ойлголтонд хүргэх ур чадваруудын нэгдэл бөгөөд байгууллагын бүх түвшинд байвал илүү үр дүнтэй. Гэвч ямарч байгууллагад манлайлагч гэсэн тусдаа албан тушаал байдаггүй. Манлайллын ур чадварт суралцаж, эзэмших нь хүн бүрт нээлттэй, боломжтой бөгөөд өөрийн зорилгодоо тууштай, суралцагч, шинийг эрэлхийлэгч, зөв хандлагатай байвал жинхэнэ манлайлагч болж чадна. Манлайлал нь мэргэшисэн алба хаагчдын заавал эзэмшсэн байх удирдахуйн ухааны үндсэн ойлголтын нэг учраас хилийн ангийн удирдах албан тушаалтанууд буюу офицерын бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, мэдлэг, заах арга зүй, сэтгэл ханамж нь манлайлалд хэрхэн нөлөөлөхийг судлан таамаглал дэвшүүлсэн.

### Манлайллын онолын үндэс

Дэлхий дээр эрт үеэс манлайлал оршсоор ирсэн боловч манлайлал хэмээх үг нь өөрөө нэлээн шинэ бөгөөд өргөн утга агуулдаг. Оксфорд их сургуулийн англи хэлний толинд өгүүлснээр "leader” буюу манлайлагч хэмээх үг нь 1300-аад онд гарч ирсэн атал “leadership” буюу манлайлал хэмээх үг XIX зууны эх хүртэл тэмдэглэгдээгүй байсан гэнэ.[1]

[1] https://languages.oup.com/

Эрдэмтэн Прентис (1961) эмх замбараагүй байдал үүсгэхгүйгээр ажилчдад сурч боловсрох боломжийг олгодог ардчилсан манлайлалын талаар өгүүлсэн байдаг. Энэхүү үзэл баримтлал нь манлайлал эрх мэдлийн хэрэпжүүлэлт эсвэл ер бусын бодит ур чадвар эзэмшсэн гэсэн ойлголтыг үгүйсгэхийн зэрэгцээ манлайллын талаарх бидний хандлагыг үндсээр нь өөрчилсөн Абрахам Залезник, Даниел Големан зэрэг сүүлийн үеийн зохиолчдын бүтээлийг илэрхийлдэг.[2]

**Мэргэжлийн ур чадвар ба манлайлал**

АНУ-ын эрдэмтэн Шарон Раунд (2007) бүх түвшний амжилттай удирдагчид олон төрлийн чухал ур чадваруудыг эзэмшдэг. Итгэл, хүндэтгэлийг бий болгохын тулд мэргэжлийн талаарх ур чадвар зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Амжилттай, үр дүнтэй удирдагчдыг ажиглах нь манлайллын чадварыг хөгжүүлэх маш сайн арга юм. Манлайлагч нь удирдан чиглүүлж, үлгэр дуурайлал үзүүлдэг бол ажилчид нь манлайллын даалгавруудыг гүйцэтгэж, практик туршлага олж авдаг. Энэ нь манлайлагчид ирээдүйн манлайлагчдыг урамшуулж, сургаж, үүрэг хариуцлагаа төлөвшүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Дээрх эрдэмтэний судалгааг үндэслэн мэргэжлийн ур чадвар манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглал дэвшүүлсэн.

**Мэргэжлийн мэдлэг ба манлайлал**

Санжай Кумар Сингх (2008) Мэдлэгийн менежментэд мэдлэгийн ахлах ажилтан, мэдлэгийн удирдлагын дарга гэж тодорхой албан тушаал байхгүй. Гэсэн хэдий ч түүнийг мэдлэгтэй менежер байгууллагын чиг хандлагыг тодорхойлж, түүнийг урагшлуулж буй хүн гэдгээрээ олны анхаарлыг татдаг.[3]

Манлайлал нь байгууллагын доторх мэдлэгийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэдэг (Donate and Guadamillas 2011, Singh 2008). Топ менежерүүдийн хангалтгүй эсвэл үр дүнгүй дэмжлэг нь мэдлэгийн менежментийн төслүүдийг бүтэлгүйтэхэд хүргэдэг (Davenport et al 1998, Xue et al 2011). Уламжлал ёсоор манлайллын судалгаа нь манлайллыг мэдлэгийн менежментийг идэвхжүүлэгч гэж тусгайлан авч үздэггүй (Lakshman, 2009). Гэсэн хэдий ч сүүлийн үеийн судалгаанууд мэдлэгийг удирдахад удирдагчдын ач холбогдлыг онцолж байна (Чу, 2016; Гамо-Санчес ба Сегарра-Наварро, 2015; Миллар нар, 2016).[4]

Дээрх эрдэмтдийн судалгаанд үндэслэн мэргэжлийн мэдлэг нь манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглал дэвшүүлсэн.

**Заах арга зүй ба манлайлал**

Манлайлал бол суралцах явдал юм. (Vaill, 1996: 126). Тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь ямарч байсан манлайлагчидын гол

[2] https://hbr.org/ (Harvard business review)

[3] https://www.tutorialspoint.com/knowledge_management/knowledge_leadership.htm

[4] Мостафа Сайяди. How effective leadership of knowledge management impacts organizational performance. Business Information Review journal 2019

үүрэг бол үргэлжлүүлэн суралцаж, эргэн тойрныхоо хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлж, удирдан чиглүүлэх явдал юм.[5]

Д.Болор (Сургалт-Зөвлөх үйлчилгээний "Эн Си Эс" ХХК-ийн гүйцэтгэх захирал) жил бүр удирдах ажилтнуудынхаа манлайлах, удирдах чадамжид олон талаас нь харсан бодит үнэлгээг өгөх, чадамжийн төвшинг тодорхойлох, менежментийн хөтөлбөрт сургалтуудаас сурсан мэдсэнээ хэрэгжүүлж байгаа байдал, цаашид хөгжүүлэх хэрэгцээг нь тодорхойлох зорилгоор удирдан манлайлах ур чадварыг үнэлэх ***“Манлайлллыг хөгжүүлэх-360° судалгаа”-ны*** аргыг хэрэглэн түвшинг тогтоож сургалтын нэгтсэн төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлснээр илүү үр дүнд хүрсэн. Мөн манлайллыг хөгжүүлэхдээ дараахи арга замуудыг хэрэглэдэг.[6] Үүнд:

- Ажлын байран дээр сургах
- Сургалт, семинарт оролцуулах
- Туршлагатай ажилтнаас суралцах, хамтран ажиллах
- Ажлын баяжуулалт, сэлгэн ажиллах
- Өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөрүүд
- Дотоод сургалт, хөтөлбөрт хамрагдах
- Бусад

Дээрх эрдэмтдийн судалгааг дэмжиж заах арга зүй нь манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглал дэвшүүлсэн.

**Ажлын сэтгэл ханамж ба манлайлал**

Манлайлал ажилчдын ажилдаа хандах хандлагад илүү хүчтэй нөлөөлдөг. Өнөөгийн байгууллагын удирдагчдын үүрэг өөрчлөгдөж, аливаа байгууллагын амжилт удирдагчдын хэрэгжүүлж буй манлайлллын хэв маягаас хамаардаг. Минцберг (2010)-ийн үзснээр жинхэнэ удирдагчид бусдад тавих анхаарал халамж, даруу зангаараа өөртөө татдаг, учир нь тэд хувь хүний ашиг сонирхлын төлөө бус хийж буй зүйлдээ өөрсдийгөө зориулдаг.

Эрдэмтэн Минцбергийн судалгаанд үндэслэн ажлын сэтгэл ханамж нь манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглал дэвшүүсэн.

*Таамаглал 1. Мэргэжлийн ур чадвар манлайлалд нөлөөлнө.*
*Таамаглал 2. Мэргэжлийн мэдлэг манлайлалд нөлөөлнө.*
*Таамаглал 3. Заах арга зүй манлайлалд нөлөөлнө.*
*Таамаглал 4. Ажлын сэтгэл ханамж манлайлалд нөлөөлнө.*

[5] Elena-Antonacopoulou. METHODS-OF-LEARNING-LEADERSHIP-TAUGHT-AND-EXPERIENTIAL. Chapters. 2003

[6] https://business.mn/2020/03/23/manlaillyn-tuhai-oilgolt/

**Зураг 1. Манлайлалд нөлөөлөх хүчин зүйлийн хамаарал**




***Тайлбар:*** *Дэвшүүлсэн таамаглал*

**Зураг 2. Манлайлалд нөлөөлөх хүчин зүйл**




***Тайлбар:*** *Prof skills- Мэргэжлийн ур чадвар, Prof know- Мэргэжлийн мэдлэг, Teaching method-Заах арга зүй, Work sat- Ажлын сэтгэл ханамж*

**Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн**

| д/д | Хувьсагч | Далд хувьсагч | Кронбах альфа | Найдвартай байдал | Дундаж утга |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мэргэжлийн ур чадвар | 0.908 | 0.929 | 0.945 | 0.741 |
| | | 0.878 | | | |
| | | 0.840 | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 0.890 | | | |
| | | 0.880 | | | |
| | | 0.760 | | | |
| 2 | Мэргэжлийн мэдлэг | 0.893 | 0.890 | 0.917 | 0.652 |
| | | 0.756 | | | |
| | | 0.823 | | | |
| | | 0.868 | | | |
| | | 0.843 | | | |
| | | 0.634 | | | |
| 3 | Заах арга зүй | 0.874 | 0.954 | 0.963 | 0.814 |
| | | 0.929 | | | |
| | | 0.938 | | | |
| | | 0.848 | | | |
| | | 0.917 | | | |
| | | 0.906 | | | |
| 4 | Ажлын сэтгэл ханамж | 0.756 | 0.890 | 0.917 | 0.650 |
| | | 0.881 | | | |
| | | 0.874 | | | |
| | | 0.676 | | | |
| | | 0.790 | | | |
| | | 0.840 | | | |
| 5 | Манлайлал | 0.790 | 0.895 | 0.919 | 0.621 |
| | | 0.769 | | | |
| | | 0.821 | | | |
| | | 0.595 | | | |
| | | 0.817 | | | |
| | | 0.875 | | | |
| | | 0.817 | | | |

*Тайлбар: Судалгааны үр дүн*

**Хүснэгт 2. Замын шинжилгээ**

| № | Таамаглал | Стандарт хазайлт | Т статистик | П үнэ цэнэ | Дундаж утга | Үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэргэжлийн ур чадвар ба манлайлал | 0.140 | 2.328 | 0.020 | 0.325 | батлагдсан |
| 2 | Мэргэжлийн мэдлэг ба манлайлал | 0.145 | 0.998 | 0.319 | 0.141 | батлагдаагүй |
| 3 | Заах арга зүй ба манлайлал | 0.157 | 1.369 | 0.171 | -0.210 | батлагдаагүй |
| 4 | Сэтгэл ханамж ба манлайлал | 0.110 | 6.108 | 0.000 | 0.668 | батлагдсан |

*Тайлбар: Судалгааны үр дүн*

Замын шинжилгээний үр дүнгээс харахад:

Таамаглал-1: Мэргэжлийн ур чадвар манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, дундаж утга 0.325, стандарт хэлбэлзэл 0.140, Т статистик утга 2.328, П үнэ цэнэ 0.020 тус тус үр дүн гарч таамаглал батлагдсан.

Таамаглал-2: Мэргэжлийн мэдлэг манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, дундаж утга -0.141, стандарт хэлбэлзэл 0.145, Т статистик утга 0.998, П үнэ цэнэ 0.319 тус тус үр дүн гарч таамаглал батлагдсангүй.

Таамаглал-3: Заах арга зүй манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, дундаж утга -0.210, стандарт хэлбэлзэл 0.157, Т статистик утга 1.369, П үнэ цэнэ 0.171 тус тус үр дүн гарч таамаглал батлагдсангүй.

Таамаглал-4: Сэтгэл ханамж манлайлалд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, дундаж утга 0.668, стандарт хэлбэлзэл 0.110, Т статистик утга 6.108, П үнэ цэнэ 0.000 тус тус үр дүн гарч таамаглал батлагдсан.

## Дүгнэлт

Хилийн цэргийн ангид ажиллаж байгаа офицер, ахлагч нарын бүрэлдэхүүнээс манлайлалд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээг хийсэн.

Судалгааг манлайлалын онолд суурилан, мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн мэдлэг, заах арга зүй, сэтгэл ханамж гэсэн хувьсагчдыг таамаглал болгон дэвшүүлж судалсан. Хүчин зүйлийн шинжилгээгээр далд хувьсагч бүрийн уялдаа холбоо, хамаарлыг нарийн шинжилсэн. Дэвшүүлсэн 4-н таамаглалаас мэргэжлийн ур чадвар, сэтгэл ханамж гэсэн хувьсагчид батлагдсан, мэргэжлийн мэдлэг, заах арга зүй гэсэн таамаглал батлагдсангүй.

Мэргэжлийн мэдлэг нь гэсэн таамаглалын 6 дахь хувьсагч буюу гадаад хэлний мэдлэг гэсэн асуултанд судалгаанд оролцогчид (60)-оос 37 хүн дундаас доогуур үнэлгээ өгсөн нь анхаарах асуудал болж байна.

Энэхүү судалгааг чанарын судалгааны суурь баримтжуулсан мэдээлэл болгон ашиглах боломжтой ч тодорхой хугацааны дараа дахин судалгааг авч харьцуулан ахиц гаргах оролдлого хийх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байна.

## Судалгааны нотлох баримтжуулсан мэдээлэл

20220512 data.txt | *ANKHBAYAR 8012.splsm | PLS Algorithm (Run No. 1)

### Discriminant Validity

Fornell-Larcker Criterion | Cross Loadings | Heterotrait-Monotrait Ratio (HTMT) | Heterotrait-Monotrait Ratio (HTMT)

| | LEADERSHIP | Professional knowledge | Professional skills | Teaching method | Work satisfaction |
|---|---|---|---|---|---|
| LEADERSHIP | 0.788 | | | | |
| Professional knowledge | 0.740 | 0.807 | | | |
| Professional skills | 0.726 | 0.862 | 0.861 | | |
| Teaching method | 0.628 | 0.860 | 0.826 | 0.902 | |
| Work satisfaction | 0.854 | 0.744 | 0.674 | 0.670 | 0.806 |

20220512 data.txt | *ANKHBAYAR 8012.splsm | PLS Algorithm (Run No. 1) | Bootstrapping (Run No. 1)

### Path Coefficients

Mean, STDEV, T-Values, P-Values | Confidence Intervals | Confidence Intervals Bias Corrected | Samples

| | Original Sampl... | Sample Mean (... | Standard Devia... | T Statistics (\|O/... | P Values |
|---|---|---|---|---|---|
| Professional knowledge -> LEADERSHIP | 0.145 | 0.141 | 0.145 | 0.998 | 0.319 |
| Professional skills -> LEADERSHIP | 0.327 | 0.325 | 0.140 | 2.328 | 0.020 |
| Teaching method -> LEADERSHIP | -0.215 | -0.210 | 0.157 | 1.369 | 0.171 |
| Work satisfaction -> LEADERSHIP | 0.669 | 0.668 | 0.110 | 6.108 | 0.000 |

20220512 data.txt | *ANKHBAYAR 8012.splsm | PLS Algorithm (Run No. 1)

### Construct Reliability and Validity

Matrix | Cronbach's Alpha | rho_A | Composite Reliability | Average Variance E

| | Cronbach's Al... | Composite Rel... | Average Varian... |
|---|---|---|---|
| LEADERSHIP | 0.895 | 0.919 | 0.621 |
| Professional knowledge | 0.890 | 0.917 | 0.652 |
| Professional skills | 0.929 | 0.945 | 0.741 |
| Teaching method | 0.954 | 0.963 | 0.814 |
| Work satisfaction | 0.890 | 0.917 | 0.650 |

## Эх сурвалжийн жагсаалт


- Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоол
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол
- https://lanquaqes.oup.com/
- https://hbr.org/ (Harvard business review)

https://www.tutorialspoint.com/knowledqe manaqement/knowledqe leadership.htm

- Мостафа Сайяди. How effective leadership of knowledge management impacts organizational performance. Business Information Review journal 2019

-Elena-Antonacopoulou. METHODS-OF-LEARNING-LEADERSHIP-TAUGHT-AND-EXPERIENTIAL. Chapter 5. 2003

- https://business.mn/2020/03/23/manlaillyn-tuhai-oilgolt/
- https://academy.edu.mn/